| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 96000 | 0 | 96000.00 | 0.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1593000 | 0 | 1593000.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **7017900** | **4705300** | **2312600.00** | **67.05** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7017900 | 4705300 | 2312600.00 | 67.05 |
| **3** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **234818900** | 0 | **234818900.00** | 0.00 |
| **30** | **Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого** | **234818900** | 0 | **234818900.00** | 0.00 |
| 300001 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 234818900 | 0 | 234818900.00 | 0.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **83603** | **Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан** | **185493900** | **148264837.5** | **37229062.46** | **79.93** |
| **12** | **Татварын бус орлого** | **8365400** | **40000000** | **-31634600.00** | **478.16** |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 8365400 | 4100000 | 4265400.00 | 49.01 |
| **12200** | **Тусламжийн орлого** | 0 | **35900000** | **-35900000.00** | **0.00** |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 0 | 35900000 | -35900000.00 | 0.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **185493900** | **148264837.5** | **37229062.46** | **79.93** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **185493900** | **148264837.5** | **37229062.46** | **79.93** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **185493900** | **148264837.5** | **37229062.46** | **79.93** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **21700000** | **18565356.44** | **3134643.56** | **85.55** |
| 210101 | Үндсэн цалин | 11200000 | 10549980.64 | 650019.36 | 94.20 |
| 210102 | Нэмэгдэл | 10500000 | 8015375.8 | 2484624.20 | 76.34 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **2712400** | **2369895.1** | **342504.90** | **87.37** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1844400 | 1646895.1 | 197504.90 | 89.29 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 217000 | 181000 | 36000.00 | 83.41 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 108500 | 90000 | 18500.00 | 82.95 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 108500 | 90000 | 18500.00 | 82.95 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 434000 | 362000 | 72000.00 | 83.41 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **32900000** | **25657900** | **7242100.00** | **77.99** |
| 210401 | Бичиг хэрэг | 2000000 | 1890600 | 109400.00 | 94.53 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13900000 | 12907400 | 992600.00 | 92.86 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 17000000 | 10859900 | 6140100.00 | 63.88 |
| **2105** | **Нормативт зардал** | **45000000** | **40346861** | **4653139.00** | **89.66** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 32000000 | 30860251 | 1139749.00 | 96.44 |
| 210502 | Хоол, хүнс | 8000000 | 9486610 | -1486610.00 | 118.58 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5000000 | 0 | 5000000.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **65000000** | **50303700** | **14696300.00** | **77.39** |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 35000000 | 31772200 | 3227800.00 | 90.78 |
| 210604 | Урсгал засвар | 30000000 | 18531500 | 11468500.00 | 61.77 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **4000000** | **3691500** | **308500.00** | **92.29** |
| 210702 | Дотоод албан томилолт | 4000000 | 3691500 | 308500.00 | 92.29 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнийн төлбөр, хураамж** | **8500000** | **2264000** | **6236000.00** | **26.64** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7000000 | 1400000 | 5600000.00 | 20.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1500000 | 864000 | 636000.00 | 57.60 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **5681500** | **5065625** | **615875.00** | **89.16** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5681500 | 5065625 | 615875.00 | 89.16 |
| **71603** | **Эрүүл мэндийн бодлого, удирдлага** | **0** | **0** | **0.00** | **0.00** |
| **80101** | **Үндсэн үйл ажиллагааны зардал** | **0** | **0** | **0.00** | **0.00** |
| **12000** | **Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0 | **121433416.7** | 0.00 | 0.00 |
| **12100** | **Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл** | 0 | **121433416.7** | 0.00 | 0.00 |

### 2.5.2 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Дүнгээр | % |
| **71602** | **Эмнэлгийн тусламж үйлчилгээ** | **43,215,200.00** | **43,215,200.00** | **-** | **100.00** |
| **80109** | **ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал** | **43,215,200.00** | **43,215,200.00** | **-** | **100.00** |
| **12** | **Татварын бус орлого** | **43,215,200.00** | **43,215,200.00** | | **100.00** |
| **12200** | **Тусламжийн орлого** | **43,215,200.00** | **43,215,200.00** | | **100.00** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 43,215,200.00 | 43,215,200.00 | | 100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **43,215,200.00** | **43,215,200.00** | | **100.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **43,215,200.00** | **41,103,709.50** | **2,111,490.50** | **95.11** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **43,215,200.00** | **41,103,709.50** | **2,111,490.50** | **95.11** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **39,948,500.00** | **37,875,008.50** | **2,073,491.50** | **94.81** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,428,000.00 | 6,330,394.00 | 1,097,606.00 | 85.22 |
| 210302 | Түлш, халаалт | 30,933,000.00 | 30,832,677.50 | 100,322.50 | 99.68 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,587,500.00 | 711,937.00 | 875,563.00 | 44.85 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,266,700.00** | **3,228,701.00** | **37,999.00** | **98.84** |
| 210604 | Урсгал засвар | 3,266,700.00 | 3,228,701.00 | 37,999.00 | 98.84 |
| **26** | **Төвлөрүүлэх шилжүүлэг** | - | **2,111,490.50** | **(2,111,490.50)** | |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 2,111,490.50 | (2,111,490.50) | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Их-Уул сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэл:***
Их-Уул сумын Эрүүл мэндийн төв нь Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр тэргүүлэгч эрүүл мэндийн төв болох, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилт тавин ажиллаж байна.

***Их-Уул сумын Эрүүл мэндийн төвийн зорилго***: *Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэн бүрт ээлтэй, хүртээмжтэй, чанартай, цогц нэгдмэл, тасралтгүй шуурхай хүргэхэд оршино.*

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

*Их-Уул сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:*

1. Эрүүл мэндийн тухай хууль
2. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
3. Эмнэлэгийн тусламж үйлчилгээний тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Төрийн албаны тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
10. Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд Эрүүл мэндийн төвийн дарга, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Их-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Их-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 369,768.4 мянган төгрөгөөр буюу 39.3 хувиар өссөн байна.

***Хүснэгт 1.*** *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 40,647.1 | 410,259.9 | 369,612.8 |
| Бараа материал | 133,088.2 | 95,749.3 | 37,338.9 |
| Үндсэн хөрөнгө | 530,272.33 | 681,152.38 | 150,880.05 |
| **Нийт хөрөнгө** | **938,826.6** | **1,308,595.0** | **369,768.4** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | **938,826.6** | **1,308,595.0** | **369,768.4** |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **938,826.6** | **1,308,595.0** | **369,768.4** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

Авлагын эхний үлдэгдэл 40,647.1 мянган төгрөг, тайлант онд 35,647.1 мянган төгрөгийн авлага барагдаж, 405,259.9 мянган төгрөгийн авлага нэмэгдэж, эцсийн үлдэгдэл 410,259.9 мянган төгрөг болсон байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 133,088.2 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 278,074.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Эрүүл мэндийн газараас 21,877.1 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 267,626.2 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, бусад 69,664.1 мянган төгрөгийн бараа материал акталж эцсийн үлдэгдэл 95,749.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 37,338.9 мянган төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 41,200.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 229,568.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 36,005.7 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэрийн дагуу акталж, жилийн эцэст 1,091,435.6 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 110,411.5 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 369,768.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,038,408,3 мянган төгрөг, нийт зарлагыг 1,038,408,3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар батлагдсан “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай”, “Орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай” 82, 128 дугаар тогтоолуудын дагуу ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл нэмэгдэж, төсвийг тодотгосноор тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг нэмж олгосон байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,348,865.0 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 43,215.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс тогтмол зардлыг санхүүжүүлж, Орон нутгийн хөгжлийн сангаас 5,600.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,467,850.5 мянган төгрөг буюу 87.8 хувьтай байна. Энэ нь эрүүл мэндийн даатгалын санхүүжилт дутуу ирсэнтэй холбоотой байна.

***Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл***

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **71602** | **Эмнэлгийн тусламж үйлчилгээ** | | | | |
| 80302 | Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон | 1,031,308.3 | 990,160.70 | 41,147.5 | 96.0 |
| 81603 | Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 456,286.5 | 329,424.9 | 126,861.6 | 72.2 |
| 83603 | Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан | 185,493.9 | 148,264.8 | 37,229.1 | 79.9 |
| 80109 | ТЗШ тогтмол зардал | 43,215.2 | 41,103.7 | 2,111.5 | 95.1 |

| НИЙТ | 1,716,303.9 | 1,508,954.1 | 207,349.8 | 85.1 |
|---|---|---|---|---|

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 43,215.2 мянган төгрөгийн санхүүжилт авч байр ашиглалттай холбоотой зардалд 37,875.0 мянган төгрөг, урсгал зардалд 3,228.7 мянган төгрөгийг зарцуулж, 2,111.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

**Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

**3.5.4 *Хүснэгт 3.* Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар**

*/мянган төгрөгөөр/*

| № | Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга | Бараа ажил үйлчилгээний нэр | Төлөвлөлт | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| 1 | Харьцуулалтын арга | Эм, эмнэлгийн хэрэгсэл | 103,509.7 | 159,630.3 |
| 2 | Шууд гэрээ байгуулах | Хангамжийн зардал | 60,907.7 | 77,008.1 |
| 3 | Шууд гэрээ байгуулах | Түлш халаалтын зардал | 22,812.1 | 30,832.6 |
| 4 | Шууд гэрээ байгуулах | Гэрэл цахилгааны зардал | 6,736.4 | 6,330.4 |
| 5 | Шууд гэрээ байгуулах | Цэвэр бохир усны зардал | 515.8 | 711.9 |
| 6 | Шууд гэрээ байгуулах | Урсгал засварын зардал | 22,240.3 | 26,388.2 |
| 7 | Шууд гэрээ байгуулах | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,569.9 | 12,678.1 |
| 8 | Шууд гэрээ байгуулах | Багаж, техник хэрэгсэл худалдан авах зардал | 26,214.7 | 10,542.2 |
| **ДҮН** | | | **250,506.6** | **324,121.8** |

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Завхан аймгийн Их-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн

буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Хаан соёмбо аудит" ХХК-ийн гэрээт аудитор Ж.Буянтогтох гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн анхан шатанд хянаж, чанарын хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Их-Уул сумын Эрүүл мэндийн төв нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,017,626.4 мянган төгрөгөөс 1 хувиар тооцож, 10.176.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувь буюу 8,141.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, гүйцэтгэлийн үе шатанд материаллаг түвшинг шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,641,502.2 мянган төгрөгөөс 1 хувиар тооцож 16,415.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувь буюу 12,311.2 мянган төгрөгөөр тогтоолоо.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завхан аймгийн Их-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдэж 14,890.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгөгдсөнийг хугацаанд нь хэрэгжүүлж, 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 23 дугаар тоотоор хариу ирүүлсэн байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,416.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг барагдуулсан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 2 | 1,416.8 | 2 | 1,416.8 | 100% |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | | | | | |
| **Нийт дүн** | 2 | 1,416.8 | 2 | 1,461.8 | 100% |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байгаагүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 27,371.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч 17,876.0 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 909.2 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 8,585.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өглөө

Залруулсан алдаа: Төсвийн гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөө гүйцэтгэлийг дутуу оруулсан, бараа материалын тайланд урсгал засварын материалыг аж ахуйн материал дансанд зөрүүтэй бүртгэсэн 17,876.0 мянган төгрөгийн алдаа байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна”, 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасан, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-тай нийцэхгүй, толилуулга, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### 5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

### 5.2 Албан шаардлага:

Байгууллагын төсвөөс Сум дундын шүүхийн 2024 оны 04 сарын 29-ний 141/ШШ2024/000058 дугаартай шийдвэрээр жолооч С.Авирмэдэд 8,585.8 мянган төгрөгийн цалин, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэлийг олгож, Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу төрд учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр төлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй зөрчилд албан шаардлага өгсөн.

### 5.3 Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

***Илрүүлэлт:*** Хоолны зардлаас 909.2 мянган төгрөгийн эм худалдан авч, зардлын эдийн засгийн ангилал гүйлгэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасныг зөрчсөн байна.

***Өгсөн зөвлөмж***: Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж, шаардлагатай тохиолдолд төсөвт зохицуулалт хийж байх;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Нийт илрүүлсэн 909.2 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөө гүйцэтгэлийг дутуу оруулсан, бараа материалын тайланд урсгал засварын материалыг аж ахуйн материал дансанд зөрүүтэй бүртгэсэн | 1 | 17,876.0 | | | 1 | 17,876.0 | 1 | 17,876.0 | | | | |
| **Дүн** | **1** | **17,876.0** | | | **1** | **17,876.0** | **1** | **17,876.0** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | АТТ | Тоо | Дүн |
| Байгууллагын төсвөөс Сум дундын шүүхийн 2024 оны 04 сарын 29-ний 141/ШШ2024/000058 дугаартай шийдвэрээр жолооч С.Авирмэдэд 8,585.8 мянган төгрөгийн цалин, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэлийг олгож, Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу төрд учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр төлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна. | 1 | 8585.8 | | | 1 | 8,585.8 | | | | | | |
| Хоолны зардлаас эмийн зардал гаргасан байна. | 1 | 909.2 | | | | | 1 | 909.2 | | | | |
| **Дүн** | **2** | **9495.0** | | | **1** | **8,585.8** | **1** | **909.2** | | | | |



**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

| | |
|---|---|
| АХЛАХ АУДИТОР | Ц.ОЮУНСУВД |
| АУДИТЫН МЕНЕЖЕР: | Х.БОЛДБААТАР |
| ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Д.БАТ-УНДРАА |

Огноо: 2025-02-24

**БОЛОВСРУУЛСАН:**

“ХААН СОЁМБО АУДИТ” ХХК-ИЙН

| | |
|---|---|
| ГЭРЭЭТ АУДИТОР | Ж.БУЯНТОГТОХ |

Огноо: 2025-02-24